




## ОЮУТНЫ ҮЗСЭН ХӨГЖМИЙН БҮТЭЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Г.Заяабат<sup>а</sup>, А.Эрдэнэболд<sup>б</sup>

<sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль, доктор;

<sup>б</sup>МУБИС-Багшийн сургууль, магистр

Холбоо барих зохиогч: [zasaba@msue.edu.mn](mailto:zasaba@msue.edu.mn) 

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

Төрийн шагналт хөгжмийн зохиолч Н. Жанцанноров “Сонгодог хөгжим сонсоно гэдэг маань ухаарлын сургууль хийж байгаа нь тэр. Ухаантай хүн юунд ч учраа олно”

### Хураангуй

Энэхүү илтгэл нь “Дэлхийн хөгжмийн түүх” болон “Монголын хөгжмийн түүх” хичээлийн хүрээнд үзсэн “Эдип хаан”, “Винд симфони”, “Дон Кихот”, “Аида”, “Classico” концерг зэрэг уран сайхны бүтээлүүдийн тухай оюутны ажиглалт, сэтгэгдэл, шинжилгээнд тулгуурласан судалгааны ажил юм. Илтгэлд эдгээр бүтээлүүдийн гол утга санаа, өрнөл хөгжлийн уялдаа, дүрүүдийн сэтгэл зүйн илэрхийлэл, хөгжмийн зэмсгийн хэрэглээ, тайзны шийдэл зэрэг үзүүлэлтийг харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд сонгодог урлагийн бүтээл бүр өөрийн өвөрмөц хэлбэр, илэрхийллийн арга барилтай ч үзэгчийн сэтгэл зүй, гоо зүйн мэдрэмжид нөлөөлөх нийтлэг зорилготой болохыг тодорхойлсон. Мөн урлаг нь соёл, түүх, хүмүүжлийн үнэ цэнийг агуулдаг хүчирхэг хэрэгсэл болохыг бататгасан.

Энэхүү судалгаанд БС-ийн III курсийн оюутнуудад “Дэлхийн хөгжмийн түүх” хичээлээр сонгодог урлагийн төрөл зүйлээс бие даан, театрт үзвэр үзэж, өөрт төрсөн сэтгэгдлийг бичсэнээрээ онцлог давуу талтай. Судалгааны үр дүн нь урлагийн бүртгэлд дүн шинжилгээ хийх, сонгодог урлагийг судлах замаар сурагчдын урлагт хандах хандлагын өөрчлөлтийг тодорхойлох явдал юм.

### Түлхүүр үг

Сонгодог урлаг, хөгжмийн илэрхийлэл, дүр, тайз, өрнөл, урлагийн боловсрол, түүх

## Удиртгал

XX зуун бол дэлхийн хүн төрөлхтний түүхэнд атомын болон сансрын эринийг авчирсан шинжлэх ухааны хөгжил дэвшилтэй, улс орнуудын эрх чөлөө, тусгаар тогтнол, дэлхийн томоохон дайнууд зэрэг түүхэн үйл явдал, баяр баясал, уйтгар гуниг, жаргал зовлонг авчирсан зуун байлаа. 1980-аад оноос нүүдэлчдийн хөгжмийн соёл, хөөмий уртын дуу, морин хуурыг олон улсын эрдэмтэн судлаачид сонирхон судлах болж, ОХУ-ын Тувагийн хөөмийчдийн Хун Хуур Ту хамтлаг баруун Европын зах зээлд нүүдэлчдийн хөгжмийн соёлыг сурталчилж эхэлжээ. Бидний мэддэгээр Энигма хамтлаг /уг нь Германы хөгжмийн төслийн нэр/ 1993 онд бүтээсэн Eyes of truth бүтээлдээ Монгол ардын уртын дуу “Алсын газрын зэрэглээ”, 1994 онд бүтээсэн Age of Loneliness дуундаа “Тосонгийн оройгоор” уртын дууг new age, world music урсгалаар найруулсан нь Монгол туургатны хөгжмийн соёлыг дэлхийд таниулах эхний амжилттай алхмууд байв (Нарантуяа, 2016)

XXI зуун бол 2001 оноос эхлэн тоологдохыг хэлнэ. Энэ зуунд уран бүтээлчид хөгжмийн хэв маягийг шинэ чиглэлүүдээр хөгжүүлсээр ирсэн (Ганхуяг, 2011.133 тал)

XXI зууны хөгжмийн урлагийн урсгал чиглэл нь нийллэг урлаг болон хөгжиж байна. Бодит хөгжим, интернэт хөгжмүүд гарч ирсэн. Электрон хөгжим, даралтат хөгжимд зориулсан сонгодог хөгжмүүд хамтлагууд гарч ирсэн. (Батжаргал, 2021) Монгол улс уламжлалт хөгжмийг олон улсад сурталчлахаар ардын дуу хөгжмийг шинэ өнгө аясаар найруулан, бүтээлээ туурвидаг Эгшиглэн, Бөртэ, Хөх монгол зэрэг хамтлагууд үүсэн, баруун Европт уран бүтээлээ сурталчилж эхлэв. Мөн Алтайн оргил, Алтай хангай, Алтан ураг, “Домог”, “Хөсөгтөн”, “Арга билэг”, “Тэнгэр аялгуу”, Жонон”, “Их Монгол”, “Алтай” зэрэг олон хамтлаг төрөн гарч, үндэсний урлагийг сурталчлах зорилгоор олон улсын хөгжмийн наадамд оролцсоор байгаа билээ. Ардын дуу хөгжим, буддын шашны болон бөөгийн хөгжмийн ая аялгуу, дуугаралтыг Алтан ураг Домог хамтлагууд рок, Арга билэг хамтлаг жазз урсгалаар, Жонон хамтлаг поп, Бөртэ, Хөсөгтөн, Их монгол хамтлаг этник фольк, Алтайн оргил электрон хөгжмийн урсгалтай сүлэлдүүлэн, уран бүтээлээ туурвиж байна.

“Алтан ураг” хамтлаг язгуур урлагийг сурталчлах дэлхийн хөгжмийн чиг хандлагатай хөл нийлүүлэхэд зоригтой эрсдэлтэй алхам хийж, тухайн үедээ шинэлэг байж, Монголын хөгжмийг дэлхийд сурталчлахад том үүрэг гүйцэтгэсэн билээ. Түүнээс хойш өөрийн гэсэн өнгө төрх, хөгжмийн хэллэгээрээ бусдаасаа арай өөр байгаа хамтлаг бол жазз урсгалаар хөгжимддөг “Арга билэг” хамтлаг юм. “Дэлхий” хамтлаг чавхдаст хөгжмийн хамгийн эртний өвөг товшуур болон хэл хуур, хэц хэнгэрэг зэрэг мартагдсан хөгжмийн зэмсгүүдийг дахин сэргээсэн билээ. Эдгээр хөгжмийн зэмсгүүдийг орчин үеийн морин хуур, ятга зэрэг хөгжмийн зэмсгүүдтэй хослуулан, дахин давтагдашгүй, урьд өмнө байгаагүй, цоо шинэ дуугаралтыг гаргасан нь мартагдсан соёлын өвийг сэргээж буй түүхэн ач холбогдолтой явдал юм (хамтлаг, 2023). Энэхүү судалгаан дээр үндэслэн багш бэлтгэдэг сургуулийн оюутнуудын хөгжмийн урлагийн сонирхлыг судалж дүн шинжилгээ хийхийг зорив.

## Үндсэн хэсэг гарчиг 1

СӨБС-ийн II, БС-ийн хөгжмийн III курсийн “Хүүхдийн дуу хөгжим”, “Дэлхийн хөгжмийн түүх” хичээлийн бие даалтын ажлаар Хөгжмийн сонгодог урлагийн бүтээлээс үзэж, өөрт төрсөн сэтгэгдэлд үндэслэн бичсэн тэмдэглэлд дүн шинжилгээ хийсэн.

1. Оюутанд хөгжмийн урлагаас эзэмшүүлэх асуудал МУБИС-ийн Багшийн сургуулийн “Багш, урлагийн боловсрол”, СӨБС-ийн “Багш, сургуулийн өмнөх боловсрол” сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байдлыг авч үзвэл:

Хүснэгт 1. Багшийн сургуулийн “Багш, урлагийн боловсрол”-ын сургалтын төлөвлөгөө

Код	Хичээлийн нэр	Кредит	Улирал	Хичээлийн хэлбэр
А.МН404	Монголын хөгжмийн түүх	2	хавар	1:2:0:0 (3)
А.МН401	Дэлхийн хөгжмийн түүх	2	намар	1:2:0:0 (3)

“Монголын хөгжмийн түүх”, “Дэлхийн хөгжмийн түүх” сургалтын хөтөлбөрт гадаадын болон дотоодын сонгодог бүтээлтэй танилцуулахаар лекц 16 цаг, семинар 32 тусгагджээ.<sup>1</sup>

Хүснэгт 2. МУБИС-ийн “Багш, Сургуулийн өмнөх боловсрол”-ын хөтөлбөр сургалтын төлөвлөгөө

Код	Хичээлийн нэр	Кредит	Улирал	Хичээлийн хэлбэр
.SM 401	Хүүхдийн дуу хөгжим	2	Намар	1:2:0:0(5)
P.MM 402	Хүүхдийн хөгжмийн боловсролын арга зүй	3	Хавар	1:2:0:0(5)

СӨБС-ийн “Хүүхдийн дуу хөгжим” 2 кредитийн агуулга бүхий сургалтын хөтөлбөрт сонсох хөгжим бүлэг сэдвийн дотор 2 цагийн лекц, 8 цагийн семинар орохоор тусгагджээ.<sup>2</sup>

Хүснэгт 3. Бие даалтын ажлын чиглэл

№	Үнэлгээ	Хэлбэр	Хугацаа	Хамрах сэдэв
1	Бие даалт-2	Дуурь, балет, жүжиг, концерт үзэх	X-XIV долоо хоног	Хөгжмийн томоохон хэлбэрийн зохиол бүтээлээс үзэж сонирхон, өөрт төрсөн сэтгэгдлээр тэмдэглэл бичих

Оюутны сонгодог бүтээлээс үзэж, өөрт төрсөн сэтгэгдлээс зарим нэгээс нь дор сийрүүлэе.

1 (Багш, урлагийн боловсрол”-ын хөтөлбөр сургалтын төлөвлөгөө. МУБИС-ийн Хөтөлбөрийн хороо 2023)

2 (Багш, Сургуулийн өмнөх боловсрол”-ын хөтөлбөр сургалтын төлөвлөгөө. МУБИС-ийн Хөтөлбөрийн хороо 2023)

*“Эдип хаан” эмгэнэлт драмын жүжиг*

*Энэхүү жүжгийг үзсэнээр хүний хувь төөрөг тавилан, амьдралын зам гэж байдаг. Хүн тэрхүү тавилангаасаа зугтаж, хялбар аргаар амьдрах аргыг хайвч тэр хэрээр хувь тавилан өөрийг нь улам тойрч дагаж байдаг гэсэн санааг ойлголоо. Жүжиг өөрт болон бусдад оюун ухаан, сэтгэл хөдлөл, урлагийг таашаах таашаал мэдрэмж, амьдралын сургамжийг олж авдаг юм байна. Тиймээс мянга сонсохоор нэг үз гэдэг шиг нэг үзчихэд гэмгүй юм аа.*

*III курсийн оюутан Б.Т*

*Бриган Янг (АНУ) “Винд симфони” үлээвэр найрал хөгжмийн оркестр*

*Анх удаа ийм том хэмжээний оркестр үзсэн бөгөөд АНУ-ын их сургуулийн үлээвэр найрал хөгжмийн аялан тоглолт гэдгээрээ онцлог байлаа. Үлээвэр найрал хөгжмийг ийм олон хүн нэгэн зэрэг нэгдэж тоглосон нь их сүрлэг сонсогдож байсан. Кинонуудын ая, манай хөгжмийн зохиолчдын зохиолыг тоглосон нь маш их таалагдсан. Бид бүгд хөгжим сонсдог, ойлгодог гэж боддог ч амьд хөгжмийн ийм сонсголонтой гэдгийг ойлгоогүй явжээ. Иймд симфони сонсож, өөртөө сэтгэлзүйн таашаал авах хэрэгтэй юм байна.*

*III курсийн оюутан М.У*

*Л. Минкус “Дон Кихот” балет*

*Урлаг гэсэн гайхалтай ертөнцөөс би балетийг нүдээрээ үзэж, чихээрээ сонсож балет гэсэн сонгодог бүтээлийг илүү ойлгон түүнд дурлан үзлээ. Миний төсөөлж байснаас илүү уран яруу сонгодог уянгалаг, сэтгэл татсан тоглолт болсон. Үзэгдэл нэгээс нөгөөрүү шилжиж, симфони хөгжим эгшиглэн дуугарах бүрт надад балетийн үйл явдал, үзэгдэл бодит байдлыг мэдрэхэд илүү тус болж, тайзны үзэгдэл нь орон зайг илүү мэдрүүл, баяр хөөр, сэтгэл хөдлөлийг бий болгож өгсөн.*

*II ангийн оюутан Б.Д*

*Өдөр 2-р курсийн оюутан Л.А*

*Ж.Верди “АИДА” дуурь*

*Ямартаа ч Египет, Этиопуудын мөргөлдөөний түүхийн үеийн нэгээхэн хэсгийн тухай үйл явдлыг харуулсан эмгэнэлт дуурь аж. Үндсэн хэв маяг нь гол дүрүүдийн дотоод ертөнцийн догдлол, шаналлыг тод томруунаар илэрхийлсэн сэтгэл зүйн драм юм. Хүн төрөлхтний гол үзэл санаа болох эх нутгаа гэсэн сэтгэлтэй зэрэгцсэн хайрын дурлалт сэтгэл, түрэмгийллийн эсрэг зөрчилдөөнөөс гадна шударга ёс, энэрэнгүй үзлийн бат итгэлийг багтаан хамруулсан.*

*III курсийн оюутан Б.А*

*“CLASSICO” гоцлол дуучдын концерт*

*Би анх удаа гоцлол дуучдын дуурь үзсэн. Дуурь үзээд, сэтгэл хангалуун гарч ирсэн. Мөн үзэж байгаа орчин үнэхээрийн сайхан тансаг, үзэгчид ч гэсэн маш соёлтой сайхан хүмүүстэй хамт үзсэн. Концерт үзсэнээр шилдэг дуучдын дуу хоолойг нэг тайзнаас сонсож, дуурийн гол дүрүүдийн дотоод сэтгэлийг дуурийн дуучид хэрхэн илэрхийлж байгаа нь гайхамшигтай байлаа.*

*II курсийн оюутан П.Э*

Дэлхийн сонгодог бүтээлээс үзээд, өөрт төрсөн сэтгэгдлийн тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээ

1. ДУУРЬ:

- Ж.Верди (Итали) “АИДА” (4 бүлэг, 7 үзэгдэл) УДБЭТ - 5 оюутан
- Ж.Верди “Трубадур” (4 бүлэг, 8 үзэгдэл) - 2 оюутан
- Ж.Россини “Севилийн үсчин” хошин дуурь (2 бүлэг, 4 үзэгдэл) - 3 оюутан
- Ж.Бизе (Франц) “Кармен” хайр сэтгэлийн (4 бүлэг) - 3 оюутан
- И.Штраус (Австри) “Сарьсан багваахай” хошин дуурь (3 үзэгдэл) - 2
- Ж.Перголези (Франц) “Ливьетта, Траколло хоёр” (2 үзэгдэл) - 4 оюутан
- Б.Дамдинсүрэн “Учиртай гурван толгой” (2 бүлэг, 4 үзэгдэл) - 2 оюутан

Хүснэгт 4. СӨБС-ийн II курсийн 11, БС-ийн III курсийн 10 оюутан

		Үзүүлэлт	1	2	3	4	5
1	дуурь	Гол утга санааг илэрхийлэн бичсэн байдал	-	2	16	7	4
2		Бүлэг, үзэгдлүүдийн уялдаа, өрнөлийг ойлгосон эсэх	-	2	13	9	5
3		Дуурийн дуучдын гол ба туслах дүрүүдийн илэрхийлэл	-	1	8	15	5
4		Хөгжмийн зэмсгийн илэрхийллийг ойлгосон эсэх	-	1	16	10	4
5		Сэтгэл хөдлөлөө тусгасан эсэх	-	2	13	10	4
6	тэмдэглэл	Техник алдаа: Зөв бичих дүрэм, үгсийн сангийн хэрэглээ	2	5	11	7	3
7		Нэг талаас хандан бичсэн эсэх	-	1	5	10	2
8		Хэд хэдэн талаас нь бичсэн эсэх	-	-	2	6	3
9		Эшлэл авч бичсэн эсэх	-	2	6	7	8
10		Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байдал	-	3	13	5	8
			2	18	103	86	46

2. БАЛЕТ /Бүжгэн жүжиг/

- А.Адан “Жизель” (2 бүлэг) УДБЭТ - 3 оюутан
- П.И Чайковский (Орос) “Хунт нуур” (2 үзэгдэл) - 4 оюутан
- П.И Чайковский (Орос) “Диваажин энд байна” (2 үзэгдэл) - 2 оюутан
- Л. Минкус “Дон Кихот” (4 бүлэг, 3 үзэгдэл) - 5 оюутан
- Д.Нацагдорж “Үйлийн гурван толгой” (3 бүлэг, 4 үзэгдэл) - 5 оюутан

## Хүснэгт 5. СӨБС-ийн II курсийн 11 оюутан, БС-ийн III курсийн 8 оюутан

		Үзүүлэлт	1	2	3	4	5
1	Балет	Гол утга санааг илэрхийлэн бичсэн байдал	4	6	10	4	4
2		Бүлэг, үзэгдлүүдийн уялдаа, өрнөлийг ойлгосон эсэх	4	7	9	17	8
3		Бүжгийн хөдөлгөөнөөр гол, туслах дүрийн илэрхийлэл	-	2	24	18	6
4		Хөгжмийн зэмсгийн илэрхийллийг ойлгосон эсэх	3	15	16	8	8
5		Сэтгэл хөдлөлөө тусгасан эсэх	4	7	16	18	5
6	Тэмдэглэл	Техник алдаа: Зөв бичих дүрэм, үгсийн сангийн хэрэглээ	5	18	21	8	6
7		Нэг талаас хандан бичсэн эсэх	5	18	9	4	-
8		Хэд хэдэн талаас нь бичсэн эсэх	-	2	8	3	1
9		Эшлэл авч бичсэн эсэх	2	1	5	6	1
10		Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байдал	3	9	15	17	6
			33	85	143	136	65

## 3. ЖҮЖИГ: Сонгодог, Түүхэн, Эмгэнэлт, Хүүхэлдэйн жүжиг

- Уильям Шекспир “Ромео Жульетта” сонгодог жүжиг, УДЭТ - 9 оюутан
- “Тамгагүй төр” дуулалт жүжиг, УДЭТ - 2 оюутан
- “Оройн дээд” үндэсний түүхэн дуулалт жүжиг (3 бүлэг, 7 үзэгдэл) МУҮДБЭЧ - 4 оюутан
- “Эдип хаан” эмгэнэлт драмын жүжиг УДЭТ - 1 оюутан
- Puppetheatre (Монгол) “Лусын хааны охидууд” МУХТ - 2 оюутан

## Хүснэгт 6. СӨБС-ийн II курсийн 10 оюутан, БС-ийн III курсийн 8 оюутан

		Үзүүлэлт	1	2	3	4	5
1	Жүжгийн илэрхийлэл	Гол утга санааг илэрхийлэн бичсэн байдал	-	-	3	7	8
2		Бүлэг, үзэгдлүүдийн уялдаа, өрнөлийг ойлгосон эсэх	-	1	3	7	7
3		Гол ба туслах дүрүүдийн илэрхийлэл	-	-	-	12	6
4		Хөгжмийн зэмсгийн илэрхийллийг ойлгосон эсэх	-	-	-	12	6
5		Сэтгэл хөдлөлөө тусгасан эсэх	-	-	2	11	5
6	Тэмдэглэл	Техник алдаа: Зөв бичих дүрэм, үгсийн сангийн хэрэглээ	1	5	8	3	1
7		Нэг талаас хандан бичсэн эсэх	-	2	2	5	4
8		Хэд хэдэн талаас нь бичсэн эсэх	-	-	4	2	3
9		Эшлэл авч бичсэн эсэх	2	1	2	3	1
10		Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байдал	-	-	5	8	5
			3	9	29	70	46


4. КОНЦЕРТ: Хөгжим, дуу, дуурь, дан найрал хөгжим, ардын сонгодог, симфони
- Бриган Янг (АНУ) “Винд симфони” ТТ-ын ордон - 2 оюутан
  - “Классико” гоцлол дуучдын концерт, УДБЭТ - 2 оюутан
  - “Celebrating bach 330th Anniversary piano concert” Александр Яковлев (Орос), С.Саяанцэцэг (Монгол) төгөлдөр хуурын хамтарсан концерт, Улсын филармони - 8 оюутан
  - “Алтан намар 2015”, УДБЭТ - 3 оюутан

Хүснэгт 7. СӨБС-ийн II курсийн 8 оюутан, БС-ийн III курсийн 7 оюутан

		Үзүүлэлт	1	2	3	4	5
1	Концерт	Гол утга санааг илэрхийлэн бичсэн байдал	2	6	12	13	4
2		Дуучдын дууны утга санааны тусгасан байдал	1	3	12	14	7
3		Концертын төрөл, жанрыг ялган ойлгосон эсэх	2	5	18	9	3
4		Хөгжмийн зэмсгийн хөг эгшгийг мэдрэн сонссон эсэх	1	3	12	14	7
5		Сэтгэл хөдлөлөө тусгасан эсэх	1	3	12	14	7
6	Тэмдэглэл	Техник алдаа:Зөв бичих дүрэм, үгсийн сангийн хэрэглээ	4	8	16	7	2
7		Нэг талаас хандан бичсэн эсэх	-	7	12	6	2
8		Хэд хэдэн талаас нь бичсэн эсэх	2	4	3	1	-
9		Эшлэл авч бичсэн эсэх	2	7	8	6	2
10		Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байдал	2	6	8	9	12
			17	52	113	93	46

График 1. Тэмдэглэлд хийсэн шинжилгээ

Дэлхийн сонгодог бүтээлээс үзээд өөрт төрсөн сэтгэгдлийн тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээ



1. Дээрх графикаас харахад балет сонгон үзсэн оюутнуудын сэтгэл хөдлөл дуурь, жүжиг, концерт үзсэн оюутны үзүүлэлтээс өндөр байгаа нь балет үггүй боловч биеийн хөдөлгөөнөөр хөгжим, тайз, орчины цогц байдлаараа хүнд илүү хүрдэгээрээ онцлогтой. ХХI зууны хөгжмийн урлаг болон дуурь, балет, жүжиг, концертыг үзсэн оюутнууд сэтгэгдэл өндөр, сэтгэлийн хөдөлгөөний байдлаа

илэрхийлж бичсэн байгаа нь урлаг хүний сэтгэлийг хөндөж чаддаг, хүнд урлагаар дамжуулан, гоо сайхны таашаал мэдрэмж өгч чаддаг гэдгийг харуулж байна.

2. Бичвэрийн талаас оюутнуудын зөв бичих дүрэм, нэг үгийг олон дахин давтаж бичсэн байгаа нь үгийг зөв оновчтой сонгож хэрэглэх байдал дутмаг байгааг харуулж байна. Мөн өөртөө итгэлгүй, сэтгэлийн хөдөлгөөнөө үгээр илэрхийлэх чадвар сул, нэг талаас нь хандаж бичсэн нийтлэг алдаа байна.

Судалгааны хамрах хүрээ болон судалгааг ямар арга, аргачлалаар боловсруулсан, чанар болон тоон үзүүлэлт бүхий статистик боловсруулалтын аргачлалыг бичнэ. Times New Roman, 11 pt үсгийн өндөртэйгөөр бичнэ.

## Судалгааны үр дүн

- Оюутны сонгодог бүтээлд хандах хандлагад дараах өөрчлөлтүүд гарч байна.
  - » Оюутан театрт үзвэр үйлчилгээний газарт биеэ зөв авч явах ёс зүй, соёлд суралцах
  - » Театрын дотоод орчин, тайзны засал чимэглэл, гэрэлтүүлэг зэрэг нь хувь хүний мэдрэмжид эерэгээр нөлөөлөх
  - » Дуурь, балет, жүжиг, концертын ялгааг мэдэх, бүлэг үзэгдлүүдийн хоорондын холбоосыг ойлгох
  - » Урлагийг ойлгон таашаах, сэтгэлийн хөдөлгөөний эерэг, сөрөг байдлыг мэдрэх мэдрэмж дээшлэх
- Оюутны тэмдэглэлд
  - » Хувь хүний өөртөө итгэлтэй, өөрийгөө илэрхийлэх, бүтээлчээр хандах хандлага тусгагдсан
  - » Төрсөн сэтгэгдлээ зөв үгээр, оновчтой, найруулга зүйн алдаагүй дүгнэлт хийж бичих чадвар хөгжинө.

## Дүгнэлт

СӨБС-ийн II курсийн оюутнуудын “Хүүхдийн дуу хөгжим” БС-ийн хөгжмийн III курсийн оюутнуудын “Монголын хөгжмийн түүх”, “Дэлхийн хөгжмийн түүх” хичээлийн бие даалтад танхимын сургалтаар дэлхийн болон монголын урлагийн сонгодог бүтээлтэй танилцуулах зорилгоор оюутны сонирхон үзсэн бүтээлийн тэмдэглэлд дүн шинжилгээ хийлээ.

1. Балет 19, жүжиг 18 оюутан үзсэнээс харахад балет болон жүжгийн гол утга санааг ойлгосон эсэх, бүжгийн хөдөлгөөнөөр гол ба туслах дүр, хөгжмийн зэмсгийн илэрхийллийг ойлгосон үзүүлэлт өндөр байгаа нь биеийн хөдөлгөөн болон хөгжмийн илэрхийллээр гаргасан дүрүүд оюутны сэтгэл хөдлөлд илүү их нөлөөлдөг юм байна.
2. Дуурь үзсэн 21 оюутнуудын бичсэн тэмдэглэлд дуурийн бүлэг, үзэгдлүүдийн уялдаа холбоо, өрнөл, дуучдын гол ба туслах дүрүүдийн илэрхийллийг ойлгосон, сэтгэл хөдлөлөө тусгасан үзүүлэлт өндөр байна. Энэ нь дуулаачдын хоолойн цар хүрээ, чадал, дууны утга санаа дүрийн илэрхийлэл оюутны сэтгэл хөдлөлд нөлөөлжээ.

3. Концертын төрлүүдээс 15 оюутан үзэж сонирхсоноос хөгжимчдийн аялгууны утга санааг тусгасан байдал, концертын төрөл жанрыг ойлгосон байдал, сэтгэлийн хөдөлгөөнийг тусгасан үзүүлэлтүүд өндөр, харин морин хуурын концертын гол утга санааг илэрхийлэн бичсэн нь сул байна.

“Мянга сонсохоор нэг удаа үз” гэдэгчлэн оюутан дэлхийн болон монголын сонгодог хөгжмийн уран бүтээлийг танхимд сууж, мэдээллийг авахаасаа илүүтэй орчинд нь очиж үзвэл гайхамшигт яруу сайхан өнгө аясыг мэдрэн, хөгжмийн хөг аялгууны эгшиглэлт нь сэтгэл баясган, оюутны танин мэдэхүй болон урлагийн мэдрэмж сэтгэл хөдлөлд маш их нөлөөлж байгаа нь оюутны бичсэн тэмдэглэлээс нь тод харагдаж байна.

## Ном зүй


1. Батжаргал, Б. (2021). <https://soundcloud.com/mongolian-national-radio/khkhi-zuuny-delkhiyn-songodog-khgzhmiyn-chig-khandlaga/s-Jsk5aqwZiUF>.
2. Ганхуяг, Н. (2011.133 тал). Хөгжим хүүхдийн ном. Улаанбаатар: Монсудар.
3. Кампбелл, Д. (2011.х.44). Хүүхдэд хөгжим сонсгож хүмүүжүүлэх нь. Улаанбаатар: Соёмбо.
4. Крысько.В.Г. (2012.х.52). Сэтгэл судлал. 2012. Улаанбаатар: Өнгө.
5. Нарантуяа, Д. (2016). <https://news.mn/r/715799/>.
6. Нарантуяа, Д. (2016). <https://news.mn/r/715799/>.
7. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр. (2015). Улаанбаатар: Хэвлэлийн үйлдвэр.
8. <https://mn.wikipedia.org/>
9. <https://www.youtube.com/watch?v=Vra-6i--nVs>
10. <https://www.youtube.com/watch?v=JiLTS0cNWQg>

## ANALYSIS OF STUDENTS' PREVIOUS MUSIC WORKS

<sup>a</sup>Zayabat G., <sup>b</sup>Erdenebold A.

<sup>a</sup>Ph.D, Teachers school, MNUE;

<sup>b</sup>Master, Teachers school, MNUE

Corresponding author: zasaba@msue.edu.mn 

### Abstract

This presentation is a research-based analysis of the student's reflections and observations on several artistic works, including "Oedipus Rex", "Wind Symphony", "Don Quixote", "Aida", and the "Classico" concert, viewed within the courses of 'World Music History' and 'Mongolian Music History'. The study compares the main ideas, structural development, character expressions, use of musical instruments, and stage design of these works. The findings reveal that although each classical artwork has its unique form and expression, they all share a common purpose—to deeply influence the audience's emotions and aesthetic perception. The research concludes that art is a powerful medium that embodies cultural, historical, and educational values.

### Keywords

Classical Art, Musical Expression, character, stage, plot, arts Education, history of music

---